

БАЯН-АЛДАР ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 4 сарын 8 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Компанийн 2018 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Баян-Алдар ББСБ ХК-ийн 2019 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг баталсугай.



ХУРЛЫН ДАРГА

Ч.ЧИНЗОРИГ

БАЯН-АЛДАР ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 4 сарын 8 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Компанийн 2018 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, 96 дугаар зүйлийн 96.5 дахь заалт, Баян-Алдар ББСБ ХК-ийн 2019 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн 2018 оны аудитын хорооны дүгнэлт болон хараат бус аудитын байгууллагаар хийлгэсэн аудитын тайлан, дүгнэлтийг зөвшөөрсүгэй.



ХУРЛЫН ДАРГА

Ч.ЧИНЗОРИГ

БАЯН-АЛДАР ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 4 сарын 8 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Компанийн нэр солих тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл, Баян-Алдар ББСБ ХК-ийн 2019 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн оноосон нэрийг “Тандэм инвэст” ББСБ ХК болгон өөрчлөхийг баталсугай.
2. Энэхүү тогтоол гарсантай холбоотойгоор хийгдэх өөрчлөлтийг холбогдох эрх бүхий байгууллагад албан ёсоор бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Б.Золжаргал/-д үүрэг болгосугай.



БАЯН ХУРЛЫН ДАРГА

Ч.ЧИНЗОРИГ

БАЯН-АЛДАР ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 4 сарын 8 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Компанийн хувьцааг хуваах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.6 дэх заалт, Баян-Алдар ББСБ ХК-ийн 2019 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, нийт 19,922,679 ширхэг энгийн хувьцааны нэрлэсэн үнэ болон нэг хувьцаа тус бүрийг 50 дахин хувааж, компанийн нэг бүр нь 2 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 996,133,950 ширхэг энгийн хувьцаатай болгож өөрчлөхийг тогтоосугай.
2. Баян-Алдар ББСБ ХК-ийн хувьцаа хуваах төслийг Хавсралт №1 -ээр баталсугай.
3. Энэхүү тогтоол гарсантай холбоотойгоор компанийн хувьцааны нэрлэсэн үнэ болон тоо хэмжээний өөрчлөлтийг холбогдох эрх бүхий байгууллагад албан ёсоор бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Б.Золжаргал/-д үүрэг болгосугай.



ХУРЛЫН ДАРГА

Ч.ЧИНЗОРИГ

БАЯН-АЛДАР ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 4 сарын 8 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Компанийн нэмэлт давуу эрхийн хувьцаа гаргах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.3 дэх заалт, Баян-Алдар ББСБ ХК-ийн 2019 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх, зах зээлээ тэлэх бодлогын хүрээнд 2019 онд 5-10 тэрбум төгрөг хүртэлх, 2020 онд 9-10 тэрбум төгрөг хүртэлх, 2021 онд 10 тэрбум төгрөг хүртэлх хөрөнгийг хөрөнгийн зах зээлээс давуу эрхийн хувьцаагаар татан төвлөрүүлэхийг зөвшөөрсүгэй.
2. Баян-Алдар ББСБ ХК-ийн нэмэлт давуу эрхийн хувьцаа гаргах төслийг Хавсралт №1 -ээр баталсугай.
3. Нэмж гаргаж буй давуу эрхийн хувьцааны нийтэд санал болгох үнэ, тоо ширхэг, нэмж гаргах давуу эрхийн хувьцаатай холбоотой асуудлуудад тухай бүр шуурхай шийдвэр гаргах бүрэн эрхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлд олгосугай.
4. Энэхүү тогтоол гарсантай холбоотойгоор нэмэлт давуу эрхийн хувьцаатай хамааралтай бүртгэлийг холбогдох эрх бүхий байгууллагад албан ёсоор бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Б.Золжаргал/-д үүрэг болгосугай



ХУРЛЫН ДАРГА

Ч.ЧИНЗОРИГ

БАЯН-АЛДАР ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 4 сарын 8 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Компанийн дүрмийн өөрчлөлтийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Баян-Алдар ББСБ ХК-ийн 2019 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг энэхүү тогтоолын Хавсралт №1-ээр баталсугай.
2. Дүрмийн шинэчилсэн найруулгыг холбогдох хууль тогтоомжинд заасан хугацаанд Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэх, дүрмийн хувийг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Золжаргал)-д үүрэг болгосугай.
3. Дүрмийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад тус тус үүрэг болгосугай.



ХУРЛЫН ДАРГА

Ч.ЧИНЗОРИГ

БАЯН-АЛДАР ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 4 сарын 8 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дэх заалт, 77 дугаар зүйлийн 77.4 дэх хэсэг, Баян-Алдар ББСБ ХК-ийн 2019 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Баян-Алдар ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийг дараах бүрэлдэхүүнээр сонгосугай.

1.1 Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнээр:

Ч.Чинзориг
Ч.Бадмаараг
Л.Очирмаа
Ц.Билэг-Өрнөх
Ч.Тэмүдэр
Б.Золжаргал

1.2 Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнээр:

А.Даваазориг
Ч.Лодойравсал
П.Чинзориг

2. Компанийн үр ашигтай ажиллагааг удирдан зохион байгуулж, холбогдох хууль, дүрэм журмын дагуу ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай



ХУРЛЫН ДАРГА

Ч.ЧИНЗОРИГ

БАЯН-АЛДАР ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 4 сарын 8 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

Зардлын төсөв батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, 62.1.15 дах заалт Баян-Алдар ББСБ ХК-ийн 2019 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Баян-Алдар ББСБ ХК-ийн 2019 оны зардлын төсвийг Хавсралт №1-р баталсугай.
2. Баян-Алдар ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны зардлын төсвийг Хавсралт №2-р баталсугай.
3. Батлагдсан төсвийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга (Ч.Чинзориг)-д үүрэг болгосугай.



ХУРЛЫН ДАРГА

Ч.ЧИНЗОРИГ